

**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ**  
**ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ**

№19/496

ШУС, НУС

2018

**ИНТЕРНЕТ ОРЧИН МЭДЭЭЛЛИЙН ӨВӨРМӨЦ ЭХ СУРВАЛЖ БОЛОХ  
НЬ**

Д.Оюунсүрэн\*

\*МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн докторант

**Түлхүүр үг:** сошиал медиа, цахим сэтгүүл зүй, сэтгүүл зүйн өөрчлөлт, эх сурвалж.

**Н**ийгмийн бүхий л салбарт хүний төрөлх хэрэгцээнээс дутахааргүй хэрэгцээтэй болсон интернетийн хэрэглээ сэтгүүл зүйд ч асар хүчтэй нөлөөлж өөрийн байр суурийг улам бүр бататгаж, шинэ үзэгдлүүдийг бий болгоод арав гаруй жил болж байна. Технологийн шинэ дэвшил, компьютерийн шинэ шинэ программууд хүмүүсийн хэрэглээ болохтой зэрэгцээд мэдээллийн хязгааргүй урсгал цаг хугацаа, орон зайн үл хамааралтайгаар эгшин зуур тархаж байгаа нь зарим талаар мэдээллийг хурдан шуурхай олж авах хэрэгцээг хангахын зэрэгцээгээр түүндээ төөрөлдөх, үл итгэх гээд сөрөг үр дагаварууд ч гарсаар байна. Доктор, профессор Б.Болд-Эрдэнийн хэлсэнчлэн “... мэдээлэл ба эх сурвалжийн харьцаа, бодит байдлын шалгуур үнэлэмжийн хил зааг улам бүр бүдгэрч хэрэглээ сонголтын давтамж, тоо хэмжээний үнэ цэнэ өсч, сан архивын ач холбогдол нь нэмэгдэх нь тодорхой. Ийнхүү үйл явдал, баримт асуудлыг сурвалжилдаг эх сурвалжийг үндэслэн мэдээллийг бүтээдэг, сэтгүүлчийн бус харин

мэдээллийн сан нөөцийг бүрдүүлэгч, эрэмблэгч, ангилагч үүрэг ажил бүхий мэргэжилтний \mediaman\ эрин төлөвшиж байна”<sup>1</sup>. Хүчээ аван улам хурдацтай хөгжиж буй цахим сэтгүүл зүй, иргэний сэтгүүл зүйг зөв хөгжүүлбэл тус салбар дэлхийтэй хөл нийлүүлэн урагшилсаар байх нь дамжиггүй.

Интернетийн буянаар хүн бүр мэдээллийн хэрэглэгч төдийгүй түгээгч нь болсон. Цахим сүлжээг ашиглан иргэн бүхэн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх, эрх чөлөөгөө хангалттай эдлэх болжээ. Харьцангуй хямд үнээр мэдээллийг олон хүнд нэгэн зэрэг цаг алдалгүй хүргэх боломж, хязгааргүй орон зайг хэвлэл мэдээллийн байгууллагууд болон жирийн иргэдэд олгож байгаа нь цахим сэтгүүл зүйн нэг чухал давуу тал нь болов. Цахим сэтгүүл зүйн салшгүй нэг хэсэг болсон иргэний сэтгүүл зүй буюу civic journalism ч манайд хүчтэй хөгжиж байна. Цахим сүлжээг ашиглан сайн дурын бичигчид буюу блогчдын тоо өдрөөс өдөрт нэмэгдэхийн хажуугаар Фэйсбүүк, Твиттерээр дамжин орж ирж байгаа хязгааргүй мэдээллийн урсгал, иргэдийн үзэл бодлыг сэтгүүлчид бид мэдээллийн эх сурвалжаа болгох нь зөв үү буруу юу, тэрхүү мэдээ мэдээлэлд хэрхэн хандах вэ

гэдэг асуудал өнөөдрийн гол сэдэв юм. 2017 оны 10 дугаар сарын байдлаар дэлхий даяар Фэйсбүүк хэрэглэгчийн тоо 2 тэрбум байгаа бол Твиттер хэрэглэгч 330 сая хүн байна.<sup>2</sup> Ийнхүү олон зуун сая хүний хэрэглээ болсон сошиал медиа Сэтгүүл зүйн шинэ хандлага болж байгаа тухай энэ салбарын томоохон эрдэмтэд хэлж байна.

**Т**ехнологийн дэвшил та биднийг телевизийн оройн мэдээгээ хүлээн суухыг нэгэнт өөрчилчихөөд байна. Ухаалаг утас, iPad хүн болгоны хэрэглээ болсноор иргэд ямар нэгэн төрийн албан хаагчийн хүнд суртал, ёс суртахуунгүй харьцаа, алс хязгаар нутагт болж байгаа байгалийн гамшиг, сонин содон үзэгдэл, авто замын осол, гал түймрийн мэдээг live хийж хормын дотор хүргэж байгаа нь сэтгүүлчид бидний хурднаас хавьгүй илүү байгаа юм. Үүнээс гадна Сошиал медиагаар явж байгаа мэдээлэл, тоо баримт, тэдний сэтгэг-дэл сэтгүүл зүйн эх сурвалж болж чадах уу гэдэг асуудал чухал. Эх сурвалж боллоо гэхэд мэдээллийн хурд чухал уу, баримт нотолгоо буюу баталгаажуулалт чухал уу гэдэг асуулт манай хэвлэлийнхний дунд багагүй маргаантай байна. Бид интернетийн орчин өөрөөр хэлбэл сайтууд, фэйсбүүк, твиттэр зэрэг нь сэтгүүл зүйн мэдээллийн эх сурвалж болж чадаж байна уу, эерэг ба сөрөг тал нь юу байна, ёс зүй, зохиогчийн эрх хэрхэн зөрчигдөж байгаа талаарх үзэл бодлыг сэтгүүлчдээс тандан ярилцсан юм.

МҮОНТВ-ийн сэтгүүлч А.Бүрэнбаатар: Хувь хүний албан ёсны хуудас бол эх сурвалж болж болох л юм. Гэхдээ найдвартай биш гэж би үздэг. Хаана юунд ашиглах вэ гэдгээс хамаарна. Оюуны өмч, зохиогчийн

эрхийн талаар яриад ч хэрэггүй гэж бодож байна.

“Эх орон” ТВ-ийн сэтгүүлч Д.Нэргүй: Албан есны ганц нэг сайтад итгэж болох ч энгээрээ үнэн бодит мэдээллийг хүргэдэг гэвэл өрөөсгөл. Сошиал бол хувь хүний үзэл бодлоо илэрхийлэх орчин. Сэтгүүл зүй биш. Харин сүүлийн үед адил мэт, тодрохгүй байгаа нь харамсалтай. Тэгэхээр сэтгүүл зүй илүү чамбайрах шаардлага бий болж байна.

МҮОНТВ-ийн сэтгүүлч А.Бүрэнбаатар: Иргэний сэтгүүл зүй гэсэн ойлголт бий. Тэр утгаараа бол нэг эх сурвалж мөн. Даанч манайхан боловсруулахгүйгээр шууд түгээдэгт алдаа байгаа юм. Аливаа мэдээллийг боловсруулахгүйгээр, баталгаажуулахгүйгээр, өөр эх сурвалжгүйгээр түгээж нийгэмд буруу ойлголт төрүүлээд байна.

“Хурд” агентлагийн Ерөнхий редактор Э.Эрдэнэчимэг: Томоохон хэвлэл мэдээллийн хэрэгсэлүүд сошиал сүлжээг ашиглах дотоод журамтай. Жишээ нь BBC.com сайтаас нь харж болох байх. Миний дадлага хийж ажиллаж байсан Голландын RNW радио бас “Social media policy” гээд маш том баримт бичигтэй. Сошиал хариуцдаг багтай байсан. Гэхдээ аль 2011 онд шүү дээ. Барууны сэтгүүл зүйд сошиал эх сурвалжуудыг чухал эх сурвалж гэж үздэг. Харин ашиглахдаа манайхан шиг шууд ашигладаггүй. Маш сайн нягтална. Шаардлагатай бол өөр эх сурвалжаар дахин баталгаажуулна. Эзэнтэй нь холбогдоно. Мөн бичлэг зураг байвал илгээхийг хүснэ. Олон нийтээс бичлэг, зураг болон бусад мэдээллийг хүлээж авдаг тогтолцоотой, тэрийгээ байнга зарлана.

“Livetv.mn” сайтын Ерөнхий редактор Chansaa Amara: news.mn, gogo.mn, ikon.mn гурав руу өдөртөө

багадаа нэг удаа ордог. Сэтгүүлч болон сайт хувийн байр сууриа илэрхийлсэн зүйлсээс илүүтэй өдөр тутам болж буй үйл явдлын мэдээлэл нь арай ханатай байдаг. Фэйсбүүк, твиттерийн хувьд нийгмийн уур амьсгал (атмосфер) ямархуу байгааг баримжаалахаас бус шууд эх сурвалжаа болгож авах нь өрөөсгөл учир болгоомжтой ханддаг.

“Gogo.mn” сайтын Ерөнхий редактор О.Ариунбилэг: Дээр хүмүүс үнэн зөвийг бичиж дээ. Харин массын хувьд твиттер, фэйсбүүк орчныг өөрийн мэдээлэл хүлээн авах ганц суваг болгочихоод /нөгөөх нь ядаж байхад бөөн хов жив, худал цуу/ тэгээд тэрийгээ хэвлэл мэдээлэлтэй андуураад "манай хэвлэл мэдээлэл баларчээ" гэж дүгнээд байдаг нь харамсалтай. Олон тооны мэдээллийн хэрэгсэл байна. Уншигч хэрэглэгч, хүлээн авагчид чухам алийг нь өөрийн мэдээллийн эх сурвалж болгох вэ гэдгээ өөрөө шийддэг. Сонголт үргэлж тэдний гарт бий. Харин хэвлэл мэдээллийнхний хувьд аль ч эх сурвалжаас мэдээлэл авсан түүнийгээ нягтлах нь зүй. "Ээж чинь чамд хайртай гэж хэлсэн ч шалга" гэдэг үг байдаг даа.

“News1.mn” сайтын Ерөнхий редактор О.Оюунсүрэн: Дэлхийн томоохон хэвлэл мэдээллийн хэрэгслүүд "social media editor", "social media coordinator", "twitter correspondent" зэрэг сүлжээнээс хэрэгцээт мэдээллээ авдаг, агентлагийнхаа мэдээг шуурхай түгээдэг албан тушаалууд бий болсон. Манайд ийм алба бий болгомоор санагддаг. Сэтгүүлчид бид сошиал медиаг дайсан мэт ад үзэх биш гадны томоохон агентлагуудын жишгээр зарим үед мэдээ сурвалжлагын санаа авах, эх сурвалжыг нягталж баталгаажуулан мэргэжлийн түвшинд мэдээл-

лээ бэлтгэж яагаад болохгүй гэж. Бүх зүйл сайн муу хоёр талтай.

“MNC” телевизийн сэтгүүлч Ч.Бат-Оргил: Сошиал нэг төрөл, бас эх сурвалж болчихсон байна лээ. Гэвч мэдээллийг нягтлахгүй амны бангаар цацаж байгаа нь цаанаа хохирогчтой болгож байгаа санагддаг. Дээх нь үед ДОХ-той хүүхэн гээд хүний амьдарлыг устгаж байсан. Орчин цагт байнга шахуу ийм үзэгдэл гарах болсон нь нийгмийн сүлжээтэй холбоотой. Зөв ашиглаж чадвал хэвлэл мэдээллийн салбарын 50 хувийг эзлэх том орон зай бий. Хоёр өнцөгтэй гэж би хувьдаа ойлгодог. Хэн яаж ашиглахаас шалтгаална. Сэтгүүлчид мэдээллийн санаа авч болно. Гол нь тэр чигээр нь тууж болохгүй. Эх сурвалж нэгээс дээш байх ёстой.

Сэтгүүлч Н.Дуламсүрэн: Фэйсбүүк хийгээд твиттер нь сайн дурынхны үзэл бодлоо илэрхийлсэн цахим засаглал. Харин сэтгүүлчид үзэл бодлоо илэрхийлэх чөлөөт мэт боловч тухайн харьяалагддаг хэвлэлийн дуу хоолой мэт гэж харагддаг болохоор зохицуулалт бас хэрэгтэй болов уу.

Сэтгүүлч П.Оюунсүвд: Ямар мэдээлэл тухайн хүн олж авахаас л шалтгаална даа. Олон янзын зүйл дотор олон л мэдээлэл байгаа. Зарим мэдээлэл эх сурвалж болж болно.

МҮОНР-ийн “Хурд” агентлагийн сэтгүүлч Д.Даваадулам: Мэдээллийн эх сурвалж болж чадна. Эерэг тал нь сэтгүүлчийн мэдэж, үзэж харж амжаагүй асуудал, үйл явдлыг орон зай, цаг хугацаа үл харгалзан шуурхай, баримттай /фото, видео/ мэдээлнэ. Энэ бол давуу тал. Харин харснаа шууд өөрийн үзэл бодол, байр сууринаас сэтгүүлч шиг хөөн сурвалжлалгүй, анхны сэтгэгдлээр мэдээлнэ. Тиймээс мэдээл-

лийг тэнцвэртэй, бодитой хүргэх тал дээр учир дутагдалтай.

“Зууны мэдээ” сонины сэтгүүлч

Энхзаяа: Сэтгүүл зүйн эх сурвалж болж чадна гэж хэлж чадахгүй. Ер нь биш л гэж үздэг. Сошиалыг эх сурвалжаа болгосон мэдээ ямар үр дагавар авчирсан тухай "Аминагийн түүх" гэсэн бодит явдал байдаг юм билээ. Дамаск хотод Амина гэж бүсгүй блог идэвхтэй хөтөлдөг нэгэн. Засгийн газрынхаа эсрэг байр суурь байнга илэрхийлдэг бөгөөд өөрийгөө ижил хүйстэн гэх зэргээр зарлаж олон нийтийг татаж чадсан. Нэг удаа Аминагийн хаягаас "Амина Засгийн газрын эсрэг байр суурь илэрхийлсний төлөө түүнийг өчигдөр шөнө баривчлаад явчихлаа" гэж өөрийгөө ах нь гэж танилцуулсан эр постолсон. Үүнийг дуулсан олон мянган найзууд нь Аминад санаа зовниж, "CNN", "New York times" зэрэг дэлхийн том хэвлэлүүд хүртэл мэдээ бэлтгэсэн байдаг. Тэр мэдээллийн мөрөөр орон нутгийн цагдаа мөрдөн шалгаж үзэхэд Амина гэж бүсгүй хэзээ ч байгаагүй, зүгээр л нэг эр хуурамч хаяг нээж тийм зүйл постолсон байсан нь илэрсэн. Харамсалтай нь дэлхийн том хэвлэлүүд хүртэл Аминагийн тухай мэдээ бэлтгэхдээ түүний талаар судлаагүй, зөвхөн сошиалд тавьсан постоор нь эх сурвалж болгосон нь ямар үр дагавартайг харуулсан хэрэг. Одоо ч тус хотод Аминагийн төлөө санаа зовдог, Аминагийн түүхд итгэсэн уншигч, сонсогч, үзэгч байдаг юм гэнэ лээ. Хэвлэлүүд нь хэчнээн алдаагаа залруулж уучлалт гуйсан ч үр дагавар нь арилаагүй. Ийм л үр дагавартай гэж бодож байгаа.

Сэтгүүлч Б.Баярмаа: Ер нь фэйсбүүк, твиттер зэрэг нь сэтгүүл зүйн мэдээллийн эх сурвалж гэхээсээ илүү иргэний сэтгүүл зүйн талбар гэж

болох юм. Эндээс Монголын сэтгүүлчид болох үйл явдлууд болон эх сурвалжуудын /төрийн албаны болон хувийн хэвшил, байгууллага, компани, төрийн өндөрлөгүүд, ЗГ, УИХ-ын гишүүд, иргэд гэх мэт бүгд багтана/ санал сэтгэгдэл, үзэл бодол гэх мэт олон төрлийн мэдээлэл, мэдээллийн санаа, сэдэв олж авах боломж байдаг гэдгийг хэлье дээ.

“ТВ5” телевизийн сэтгүүлч

Д.Доржбат: Миний хувьд твиттер, фэйсбүүкээс зарим анхаарал татсан тоо баримт олж авч түүнийгээ баталгаажуулан эрэн сурвалжилж олон мэдээ сурвалжлага бэлтгэж байсан. Зарим талаараа найдвартай биш ч зарим үед эх сурвалж болж чаддаг гэж бодож байна.

“Үндэсний шуудан” сонины

сэтгүүлч О.Отгонжаргал: Мэргэжлийн сэтгүүлчид бид сошиалаар явдаг таамаг төдий найдваргүй мэдээллээс татгалзах хэрэгтэй.

**С**этгүүлчид маань сошиал медиагийн мэдээлэлд хэрхэн ханддагаа ингэж хуваалцсан юм. Ер нь бол ямар нэг хэмжээгээр мэдээллийн эх сурвалж болдог, гагцхүү түүнийг баталгаажуулж, өөр бусад эх сурвалжаар баяжуулах нь зүйтэй гэдэг дээр олонх нь санал нэгтэй байна. Сошиалын мэдээ мэдээлэл бол үнэндээ “Хоёр үзүүртэй зүү” юм. Үнэн бодитой ч байж болно, худал ч байж болно. Баталгаажуулах нь чухал байгаа юм. “Баримтыг бодит мэдээлэл болгож, түүний үнэ цэнэ, ач холбогдлыг тодорхойлж, хүлээн авагчдын сэтгэл зүйд нөлөөлөх чадварыг дээшлүүлдэг гол хүчин зүйл бол эх сурвалж юм”<sup>3</sup>. Тийм учраас мэргэжлийн сэтгүүл зүйн амин сүнс нь эх сурвалж болох нь тодорхой. Сошиал медиаг эх сурвалжаа болгож байгаа сэтгүүлчид

тухайн эх сурвалжаа чадварлаг ашиглаж, эрэл хайгуул хийж, баталгаажуулан бүрэн мэдээлэл өгөх нь учир дутагдалтай хэвээр байна. Өөрөөр хэлбэл хагас дутуу боловсруулалттай, олсон баримтаа олон эх сурвалжаар баталгаажуулаагүй, гүйцэтгэл боловсруулалт тааруу мэдээ сурвалжлага ноёлж байгааг үгүйсгэх аргагүй юм.

Ромын нэгэн сургуулийн утга зохиолын багш Томмассо де Бенедитти гэгч хүн твиттерт Италийн Ерөнхий сайд болон Афганистаны Ерөнхийлөгчийн өмнөөс жиргэдэг байжээ. Тэрээр Ромын пап 16 дугаар Бенедитти, ОХУ-ын Ерөнхийлөгч асан М.С.Горбачёв, Сирийн удирдагч Башар Аль Ассад зэрэг олны танил хүмүүсийг нас барсан тухай худал мэдээлээд, гүн эмгэнэл илэрхийлж, олон удаа шуугиан тарьж байсан юм.

Сирийн удирдагчийг нас барсан тухай мэдээ сошиалаар тархсаны дараа дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ огцом өсч газрын тосны борлуулагчид өндөр ашиг олж, худалдан авагчид эдийн засгийн хохирол амсч байсан гашуун түүх бий. Одоо манай улсад нэр зүсээ нууцалсан хуурамч хаягтай жиргээчид асар олон бий. Ялангуяа улс төр бизнесийн хүрээнийхэн голдуу ил далд 2 хаягтай байх бөгөөд зарим нь олны өмнө хэлж чадахгүй байр сууриа хуурамч хаягаасаа илэрхийлэх, зарим нэг нь хэн

нэгнийг гутаах доромжлох мөн өөрт ашигтайгаар нийгмийн сэтгэл зүйг өөрчлөх хуурамч мэдээлэл цацахад ашиглаж байна.

Сошиал хэрэглэгчийн контент болоод коммент нь мэдээллийн ашигтай эх сурвалж болохоос сэтгүүл зүй биш учраас хэрэглэгчийн контент руу хэт хошуурвал сэтгүүл зүйн хөгжлийг хойш чангаах нь тодорхой. Тиймээс аливаад ул суурьтай хандах, баримт нотолгоогоор баталгаажуулах нь чухал байна.

«

*Зарим сонин, сайт, телевизүүд фэйсбүүк, твиттерийн мэдээллийг тэр чигээр нь авч ашиглах нь их байна. ХМХ-үүд “Сошиалын сонин хачин”, “Онцлох жиргээ” гэх мэтээр булан, хөмсөг нээж шууд хүргэж байгаа нь тийм ч сайн зүйл биш юм. Сошиалд байгаа бичвэрүүд хүний нэр төр гутаасан агуулгатай, тоо баримт мэдээлэл өгсөн \үнэн бодитой эсэх нь тодорхойгүй\, хүний үзэл бодол гээд олон янзын агуулгатай байгаа учраас ялгамжтай хандах нь зүйтэй*

»

Одоогоор зарим сонин, сайт, телевизүүд фэйсбүүк, твиттерийн мэдээллийг тэр чигээр нь авч ашиглах нь их байна. ХМХ-үүд “Сошиалын сонин хачин”, “Онцлох жиргээ” гэх мэтээр булан, хөмсөг нээж сошиал сүлжээний агуулгыг шууд хүргэж байгаа нь тийм ч сайн зүйл биш юм.

Сошиалд байгаа бичвэрүүд хүний нэр төр гутаасан агуулгатай, тоо баримт мэдээлэл өгсөн \үнэн бодитой эсэх нь тодорхойгүй\, хүний үзэл бодол гээд олон янзын агуулгатай байгаа учраас ялгамжтай хандах нь зүйтэй. Манай улсын томоохон хэвлэл мэдээллийн хэрэгслүүд сошиалын сонин хачныг шууд эх сурвалж болгон олон нийтэд түгээж байна. Тухайлбал ТВ9 телевизийн “Монгол коммент”, NTV телевизийн “Social news” хөтөлбөр, ТВ5 телевизийн “Цаг” хөтөлбөрт “Энэ өдрийн онцлох жиргээ” булан, ETV телевизийн



Өглөөний хөтөлбөрт “Сошиалийн сонин” булан, Өдрийн сонины “Цахим ертөнц” жиргээний булан зэргийг нэрлэж болно.

Өдөр тутмын сонинуудаас УБ хотноо хамгийн олон уншигчтай “Өдрийн сонин” “Цахим ертөнц” нэртэй онцлох жиргээний булантай. Энэ буландаа хүмүүсийн жиргээг шууд хуулбарлан тавьдаг нь ёс зүйн хувьд, мэргэжлийн сэтгүүл зүйн туршлагатай сонины хувьд хэр зэрэг зүйд нийцэж байгаа нь эргэлзээтэй байна.

“Зууны мэдээ” сонин “Сошиалын сонин” буландаа хэн нэгэн хүний анхаарал татсан жиргээг онцлон тухайн сэтгүүлч тэр жиргээнд дурдагдсан баримтыг урьд хожид болсон үйл явдлын баримт мөн шинэ баримт болоод өөрийн үзэл бодлоор баяжуулан бичил хэмжээний бичвэр болгож бичсэн жишээг үзүүлэе. Энэ нь сэтгүүл зүйн шаардлага чанарт нийцсэн байдал нь баримт бүрдүүлэлт, бичлэгийн ур чадвараас шалтгаалан янз бүр байна. Тухайлбал, дор зургаар үзүүлсэн жиргээнд үндэслэн “Цэнхэр үст” Цэрэн С.Баярцогтын мөнгөний араас явжээ (2016 оны 11 сарын 30) гарчигтай бичвэрийг “Зууны мэдээ” сонины сэтгүүлч Т.Сайхан нийтэлжээ.



Tseren Enebish  
@tornadoTseren

Монголын улс төрчдын ард түмнээсээ хулгайлсан \$ Швейцарын дансанд буйг прокурорт нотлож, гэрчлэхээр би Швейцарт ирээд байна.

Translate from Russian  
11/29/16, 6:35 AM

VIEW TWEET ACTIVITY

101 RETWEETS 77 LIKES

“Цэнхэр үст Цэрэн дахин нэгэн шуугиан тарилаа. Тэрээр Швейцарьт оффшорчдын Монголоос "хулгайлж" хадгалуулсан их мөнгийг олох их аянд гарсан

байна. Цэрэн энэ тухайгаа фэйсбүүктээ "Монголын улс төрч тухайлбал 1992 оноос улс төрд 23 насандаа орсон С.Баярцогт Швейцарь улсын банкинд нэг сая доллар мартсан асуудал 2013 онд яригдаж байв. Швейцарийн Зохион байгуулалттай гэмт хэргийн ажиглагчид нэртэй олон улсын байгууллагатай холбогдон тэднээр дамжуулан хуулийн фирмтэй ажиллаж эхэлсэн. Швейцарьт албан ёсоор С.Баярцогтын эсрэг хэрэг прокурор дээр үүссэн ба түүний гурван найз буюу данс хамтран эзэмшдэг хүмүүсийг илчлэх, энэ мөнгө Монгол Улсын газар, уул уурхай, цаашилбал авилга хахуулиас орж ирсэн эсэх, хэрэв авилга газрын наймаанаас орж ирсэн бол Монгол Улсад буцаах эрх зүйн орчин байгаа эсэхийг шалгуулахаар Швейцарийн хуулийн хүрээнд бид ажиллаж байна. Биднийг прокурор асууж шаардлагатай баримтуудаа гаргахыг хүслээ. Тун удахгүй надтай хамт яваа эмэгтэйг би танилцуулж ярилцлага хүргэх болно. Энэ хооронд Монголд суугаа ар гэр, ахан дүүс, найз нөхдөд алив нэг таагүй асуудал тохиолдвол энэ бүхний хариуцлагыг Монголын төр хариуцах болно гэдгийг намайг дэмждэг бүх хүмүүст урьдчилан анхааруулъя. Чих тавиарай. Цэрэнгээс 2016.11.29" хэмээн бичжээ. Мөн "Монголын улстөрчдийн ард түмнээсээ хулгайлсан ам.доллар Швейцарийн дансанд буйг прокурорт нотолж гэрчлэхээр би Швейцарьт ирээд байна" гэсэн байна. Ямартай ч Цэрэн С.Баярцогтын сая ам.долларыг ил болгохоор Швейцарьт очсон юм байна. Харин энэ зуур С.Баярцогт Америкт номын дуу сонсч яваа сурагтай байна" гэж бичжээ. Энэ бичвэрийн хувьд сэтгүүлчийн хөдөлмөр эрэл хайгуул огт ороогүй, Цэрэн хэмээх хүний фэйс-

бүүк хаяг болон твиттерт нийтэлсэн мэдээллийг нь нийлүүлээд бичсэн байна.

Манай хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, цахим мэдээллийн сайт эрхлэгчид нийгмийн сүлжээн дэх эх сурвалжуудад хандах хандлагаа өөрчилж анхааралдаа авч чанартай, үнэн бодитой, баталгаа нотлгоотой, шуурхай байх зэрэг мэргэжлийн сэтгүүл зүйн зарчим, шаардлагаар иргэний сэтгүүл зүйгээс ялгарах хэрэгтэй байна.

“BBC”, “CNN”, “ABC News”, “Reuters”, “CBS News” зэрэг дэлхийд тэргүүлэгч мэдээллийн агентлагууд, “Нью-Йорк таймс” сонин зэрэг томоохон хэвлэл мэдээллийн хэрэгслүүд 2009 оноос эхлэн “social media editor”, “social media coordinator”, “twitter correspondent” зэрэг сүлжээнээс хэрэгцээт мэдээллээ авдаг, нягталдаг, агентлагийнхаа мэдээг шуурхай түгээдэг албан тушаалууд бий болгосон. Барууны сэтгүүл зүйд сошиалийг нэгэн эх сурвалж гэж үздэг. Харин ашиглахдаа манайхан шиг бараг шууд ашигладаггүй, сайтар баталгаажуулдаг, баяжуулдаг.

Хүссэн хүсээгүй Сэтгүүлч хэмээх мэргэжлийг мэргэжил нэгт нөхөд маань хааж хаацайлж, бусдаас харамлан хавдарж суусан ч мэдээлэл технологийн дэвшингүй хөгжил сошиал медиа, иргэний сэтгүүл зүйтэй айл хөрш харилцан ашигтай зэрэгцэн оршихыг нөхцөл байдал шаардаж байна. “...сошиал медиа нь зөвхөн мэдээллийн эх сурвалж байгаад зогсохгүй ирээдүйд мэдээллийн хэрэгсэл (media) болох нь гэсэн дүгнэлт ч бий”<sup>4</sup>.

Саяхан АНУ-ын “Pew” нийгмийн судалгааны төв насанд хүрсэн америкчуудын 62 хувь нь нийгмийн сүлжээнд итгэж байгаа нь дөрвөн

жилийн өмнөхөөс 13 хувиар өссөн гэсэн судалгааны дүнг танилцуулсан. Манайд нийгмийн сүлжээнд итгэгчдийн тоо үүнээс ч өндөр гарах магадлалтай.

**2**011 оны хавар эхэлсэн Арабын хувьсгалыг, 2016 оны АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн үр дүнд нийгмийн сүлжээ асар их үүрэг гүйцэтгэснийг судлаачид онцолдог. Түүнээс гадна энэ сонгуулийн санал хураалтын болон сонгуулийн өмнөх кампанит ажлын үеэр нийгмийн сүлжээний идэвх оролцоо үлэмж өндөр байсны зэрэгцээ тэрхүү сүлжээнд тархсан худал, хуурмаг мэдээллийн эзлэх хувь төдий чинээ өндөр байсан нь хэвлэл мэдээллийнхэн төдийгүй улс төр судлаачдын хөндөж байгаа халуун сэдвийн нэг болоод байна. Иймээс тэрхүү баримт нотолгоогүй, хуурамч мэдээллийн хүчтэй давалгаанаас яаж сэргийлэх вэ, хууль эрх зүйн орчинг чангатгах ямар гарц боломж байгаа талаар идэвхтэй хэлэлцэх боллоо.

Интернет бол “Виртуал нийгэм” учраас түүнийг төр хянана гэдэг бүтэшгүй гэсэн тунхаглал байдаг ч худал хуурмаг мэдээллийг хянах, устгах нийгмийн сүлжээг эмх цэгцэнд оруулах гарц гаргалгаа, дүрэм журам хэрэгтэй байгаа талаар улс орнууд ярьж эхлээд байна. Хойд хөршийн тухайд 2016 оны 4-р сард “ОХУ-д блог, олон нийтийн сүлжээний харилцаа, мэдээллийн үйл ажиллагаанд тавих хяналтыг чангатгах тухай” хууль батлан 2017 оны 8-р сарын 1-нээс хэрэгжүүлж эхлээд байгаа. Энэ хуульд зааснаар аливаа блог, цахим хуудас болон интернет сайт өдөрт 3000 гаруй хандалттай бол олон нийтийн мэдээллийн хэрэгсэл хэмээн бүртгүүлж ОХУ-ын Хэвлэл мэдээллийн хэрэгслийн

тухай хуулийг дагаж мөрдөх үүрэгтэй болж байна. Түүнчлэн “хувийн интернет сайт болон цахим хуудас дээрээ мэдээлэл нийтлэгч этгээд” гэсэн хэсэгт багтсан блогчин нь өөрийн бичсэн нягтлаагүй баримт материал болон түүнд уншигчдын бичсэн сэтгэгдлийн өмнөөс 500 мянган рублээр торгуулах, эсвэл 30 хоног хүртэл үйл ажиллагаагаа зогсоолгох шийтгэл хүлээх юм. Мөн шинэ хуулиар нийгмийн сүлжээний мэдээ нийтлэл бүрийн хандалтын тоог хянах, ОХУ-ын Засгийн газрын агентлагуудаас олон нийтийн сүлжээнд хяналт тавих, хэрэв олон нийтийн сүлжээнүүд тэрхүү хяналт шалгалтад саад учруулбал төр, засгийн зүгээс тэдгээр сүлжээний компанийн үйл ажиллагааг зогсоох зэрэг зүйл заалтууд байгаа юм.

Манай улсын хувьд ч нийгмийн сүлжээнд анхаарал хандуулж, бусад улс орнуудын туршлагыг судлан үзэх шаардлага гарч байна. Манайд хуулбар мэдээгүй, захиалгат бичвэргүй сайтыг олоход тун бэрх бөгөөд интернетийн орчинг эрүүл мэдээллийн орчин болгон хувиргах эрх зүйн орчин дутагдаж байна.

Хүний үг хэлэх эрх чөлөөг бүрэн утгаар нь ямар ч хил хязгаар, цензургүй гаргаж байгаа сошиал медиагийн энэ давуу тал сөрөг үр дагаварыг ч авчирч байна. Олон нийтийн сүлжээг үзэл бодол, байр сууриа илэрхийлэх талбар болгохоос гадна

худал мэдээлэл түгээх, олон нийтийн тархи угаах, бодит байдлыг гуйвуулах, өрсөлдөгчөө намнах хэрэгсэл болгон ашиглах нь улам бүр ихэсч байна. Бусдын захиалгаар төлбөртэй пост, сэтгэгдэл бичих, нийгмийн сэтгэл зүйд нөлөөлөх үзэгдэл 2016 оны УИХ-ын сонгуулиар манайд түлхүү ажиглагдсан. Энэ бүх нөхцөл байдал нь сошиал медиа хэрэглэгчид болон сэтгүүлчдийг тухайн мэдээллийн үнэн зөвийг ялгаж салгаж чадах мэдлэг, мэдрэмж, анализ дүгнэлт хийх чадварыг шаардаж байна. Үнэндээ иргэд интернетийг жинхэнэ утгаар нь ашиглах бус түүний нөлөөнд автсаар байна.

#### Ишлэл

- <sup>1</sup> Болд-Эрдэнэ Б. 2014. Нийгэм, интернет, сэтгүүл зүй. УБ. 17 дахь тал
- <sup>2</sup> [www.statista.com/](http://www.statista.com/)
- <sup>3</sup> Зулькафиль М. 2009. Сэтгүүлчийн ур чадвар-1 УБ. х.36
- <sup>4</sup> Идэржаргал Д. Сэтгүүл зүй ЭШБ. // Сошиал медиагийн эрин үе дэх сэтгүүл зүйн өнөөдөр ба ирээдүй. 2015. 91 дэх тал

#### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Болд-Эрдэнэ Б. 2014. Нийгэм, Интернет, Сэтгүүл зүй. УБ.
2. Зулькафиль М. 2017. Сэтгүүл зүйн судалгааны бүтээлүүд боть 3. Орчин үеийн медиа: шинэчлэл, чиг хандлага УБ.
3. Зулькафиль М. 2017. Сэтгүүл зүйн судалгааны бүтээлүүд боть 10. Сэтгүүлчийн хөдөлмөр: Ёс зүй хариуцлага, үнэлэмж. УБ.
4. Сэтгүүл зүй ЭШБ. 2015 он. УБ.